

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДААР ТОМИЛУУЛАХ  
АСУУДЛААРХИ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 10 дугаар  
сарын 17-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Даваажанцангийн Сарангэрэлийг томилуулах саналыг 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.6 дахь заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Ерөнхий сайдын дээрх саналыг хэлэлцлээ.

Даваажанцангийн Сарангэрэл нь 1983 онд ЗХУ-ын Омск хотын Технологийн техникум, 1990 онд ЗХУ-ын Ростов хотын Улсын их сургуулийг сэтгүүлч мэргэжлээр төгссөн, 2005 онд ОХУ-ын Москвагийн их сургуульд сэтгүүл зүйн ухааны магистрийн зэрэг хамгаалсан.

Даваажанцангийн Сарангэрэл нь 2012 оноос хойш Улсын Их Хурлын гишүүнээр ажиллах хугацаандаа эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход хичээл зүтгэлтэй ажилласан бөгөөд, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагчаар, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүнээр ажилласан, одоо Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүн М.Билэгт Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нь эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар идэвх санаачлагатай ажиллаж ирсэн, тухайн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадвартай улс төрч учраас эрүүл мэндийн сайдаар томилохыг дэмжиж байгаагаа илэрхийлэв.

Даваажанцангийн Сарангэрэлийг Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар томилуулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.


Үүнтэй холбогдуулан Аюушийн Цогцэцэгийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн боловсруулж, “Засгийн газрын зарим гишүүдийг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг оруулахаар тогтсон болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Даваажанцангийн Сарангэрэлийг томилуулах тухай Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**П.ЭНХ-АМГАЛАН**